

Оюутан бие хүний онцлогийг үнэт зүйлстэй холбон судалсан судалгаанд хийсэн шинжилгээ*Э.Нарантунгалаг***МУБИС, Биеийн тамирын сургууль, Биеийн тамир спорт онол, арга зүйн тэнхим***Хураангуй**

Энэхүү илтгэлийн хүрээнд багш бэлтгэх сургуульд элсэн суралцаж байгаа нэгдүгээр дамжааны оюутны бие хүний төлөвшлийг судлахыг зорьсон болно. МУБИС-ийн Нийгэм Хүмүүнлэгийн ухааны сургууль, Математик байгалийн ухааны сургууль, Багшийн сургуулийн нийт 194 оюутнаас судалгаа авч, үр дүнд шинжилгээ дүгнэлт хийв. Р. Кеттелийн боловсруулсан 16 хүчин зүйлсийн задлан шинжлэлийн сорилын үр дүнгээс харахад оюутнуудын хоорондын харилцаа, сэтгэл хөдлөлийг илтгэх “L” болон “O” үзүүлэлтүүд дунджаас дээгүүр түвшинд байгаа нь ихэнх оюутнуудад эргэлзээ тээнэгэлзэл, бусдын алдаа, айдас, өөртөө итгэх итгэл багатай, аливаа асуудалд дарамт үзүүлэх зэрэг сөрөг шинжүүд илэрч байгааг судалгаагаар харуулж байна.

Харин В үзүүлэлт (2,7) дунджаас доогуур гарсан байгаа нь биеэ даасан биш, шийдвэр гаргахдаа бусдын үзэл бодлыг дагадаг, хийсвэрлэх, бүтээлч сэтгэлгээ сул хөгжсөн, өнгөц, явцуу сэтгэдэг зэрэг сул талууд байгааг харуулж байна. Тиймээс оюутан ба бие хүний төлөвшлийн асуудалд анхаарал хандуулан хөгжлийн цогц бодлого шаардлагатай байна гэсэн дүгнэлт хийж байна.

Түлхүүр үг

Бие хүний сэтгэл зүйн онцлог, төлөвшил, 16 хүчин зүйлийн задлан шинжлэлийн сорил, үнэт зүйлийн баримжаалал

Удиртгал

Манай орны дээд боловсролын шинэчлэлийн үндсэн зарчим нь үнэт зүйлс, чадамжид суурилсан мэргэжлийн чиг хандлага төлөвшүүлэх, сургахаас хүмүүншүүлэх, мэдлэг төвтэйгөөс, хувь хүний хэрэгцээ сонирхол, дотоод нөөц боломжид суурилсан үйл явц төвтэй сургалт руу, тооноос чанарлуу гэсэн үзэл баримтлалаар тодорхойлогдон хөгжиж байгаа билээ. Сүүлийн жилүүдэд монгол хүний үнэт зүйлсийг тодорхойлох суурь судалгааны ажил өргөжин эрчимжиж байна. Монгол хүний үнэт зүйлсийг тодорхойлох суурь судалгаанд нийгмийн давхаргын гол төлөөлөл болох оюутан залуусын сэтгэл зүйн онцлог, төлөвшлийн судалгаа чухал ач холбогдолтой гэж үзэж, судалгааны үр дүнд шинжилгээ хийхийг зорьсон болно. Сэтгэл зүйн зүйн хувийн онцлог гэдэг бол хүмүүс хоорондын харилцаа, оршихуй, үнэт зүйлсийн баримжаалалд тогтвортой илэрч байдаг шинж чанарын цогц нэгдэл. Оюутан залуусын бие хүний сэтгэл зүйн онцлогийг судалснаар тэдний нийгэмшлийн эерэг болон сөрөг талуудыг илрүүлж, улмаар үнэт зүйлсийн чиг баримжаалалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох боломжтой бөгөөд судалгааны нэг шинэ чиглэл байх болно гэж үзэж байна.

Оюутан залуусын төлөвшлийг судлан дэмжин чиглүүлж ажилласнаар мэргэжлийн үнэлэмжийг дээшлүүлэх нөхцөл бүрдэнэ.

Судалгааны арга зүй

Оюутан болсноор мэргэжлийн талбарт өөрийгөө таньж тодорхойлох, суралцах явцад тэдний үнэт зүйлсийн чиг баримжаалал тогтож, хувь хүний амьдралын байр суурь, амьдралын утга учир, хүсэл зорилгыг тодорхойлж эхэлдэг. Хувь хүн болон мэргэжлийн үнэт зүйлсийн баримжаалал нь бие хүний сэтгэл зүйн хувийн онцлог, төлөвшилтэй уялдаа холбоотой явагддаг зүй тогтолт үзэгдэл. В.Н.Мясищев (1997), Г.М.Андреева (1997), С.С.Бубнова (1997), Д.В.Каширский (2014) зэрэг оросын эрдэмтэн судлаачид хувь хүний үнэт зүйлсийн талаарх онолын үзэл баримтлалыг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулжээ. Ялангуяа үнэт зүйлс болон бие хүний хувийн онцлогийн хоорондын хамаарал холбоо, харилцан нөлөөллийн асуудлыг онолын үүднээс судлан шинжилсэн байна. Барууны судлаачид тухайлбал, Дж.Ротер¹ (1982), Г.Олпорт² (1960), М.Рокич³ (1973) нар үнэт

¹ Rotter J.B

² Allport, G. W

³ Rokeach

* ✉ sk_naraa26@yahoo.com

зүйлсийн когнитив загвар, онолыг боловсруулж, бие хүний сэтгэл зүйн бүтэц тогтолцоонд үнэт зүйлс тодорхой байр суурь эзэлдэг гэж үзэж байна. Дээрх судлаачдын онолын үзэл баримтлалыг үндэслэн бие хүний сэтгэл онцлог, нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулахыг зорьсон болно.

Оюутны бие хүний сэтгэл зүйн хувийн онцлог төлөвшлийн ерөнхий төлөв байдлыг илрүүлэхэд Америкийн сэтгэл зүйч Р.Кеттелийн боловсруулсан 16 хүчин зүйлсийн задлан шинжлэлийн сорилын “С” хувилбарыг сонгож, судалгаа явуулсан болно. Тус аргачлал нь бие хүний сэтгэл зүйн онцлог, төлөвшлийн төлөв байдлыг олон хүчин зүйлсээр дамжуулан судалдаг. Хүчин зүйлс гэдэг бол зан төлөвийн илрэлийн харьцангуй тогтвортой шинжүүдийн иж бүрдэл. Хүчин зүйлст задлан шинжлэлийн аргыг судалгаанд хэрэглэнээр бие биеэсээ харьцангуй бие даан орших хүчин зүйлсийг илрүүлэх бөгөөд тэдгээрийн тусламжтайгаар бие хүний зан төлөв, сэтгэл зүйн ялгаа онцлогийг ялган хэмжиж тодорхойлох боломж бүрддэг.

Хүснэгт 1

16 хүчин зүйлсийн сорилын хэмжүүр

Сэтгэл зүйн онцлог чанарууд	16 хүчин зүйлсийн шинжилгээний хэмжүүрүүд
Оюун ухаан, бүтээлч сэтгэлгээ	B, M, Q ₁
Бусдыг ойлгох, харилцан нөлөөлөх харилцах онцлон	A, N, L, H, F, E
Сэтгэл хөдлөлөө хянан зохицуулах, илэрхийлэх зан чанар	O, Q ₃ , Q ₄ , C
Санаачилгатай, хичээнгүй, зарчимч зоригийн зан чанарууд	Q ₃
Хүлээцтэй тэвчээртэй зан чанар гэх мэт	C

Судалгааны үр дүн

Оюутнуудад бие хүний сэтгэл зүйн хувийн онцлог чанарууд хэрхэн төлөвшиж байгаа төлөв байдлыг илрүүлэх зорилгоор МУБИС-ийн нэгдүгээр дамжааны оюутнаас авсан судалгааны үр дүнд шинжилгээ хийв. Судалгаанд нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль, математик байгалын ухааны сургууль, багшийн сургууль гэсэн гурван салбар сургуулийн 204 оюутан оролцсон.

Хүснэгт 2

Судалгааны түүвэр

МУБИС		
Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль	Математик байгалын ухааны сургууль	Багшийн сургууль
85	75	44
194		

Дээрх сорилоор авсан судалгааны үр дүнгийн боловсруулалтыг SPSS программ дээр хийж, арифметик дундаж, стандарт дундаж хазайлтыг тус тус тооцоолон гаргав.

Хүснэгт 3


Стандарт дундаж хазайлт

№	Хамрагдсан хүрээ	Тоо	Хүчин зүйл	Хамгийн бага утга	Хамгийн их утга	Дундаж утга	Стандарт хазайлт
1.	Оюутан	204	MD	1	12	5.9	2.1

Судалгаанд оролцсон нэгдүгээр дамжааны оюутан бие хүний сэтгэл зүйн онцлогийн зураглалыг графикаар харуулбал дараах байдалтай байна.

График 1

Оюутан бие хүний сэтгэл зүйн онцлогийн зураглал



16 хүчин зүйлсийн сорилоор судалсан судалгааны үр дүнгээс харахад бие хүний сэтгэл зүйн онцлог шинж чанарын олонх үзүүлэлтүүд дундаж хэвийн буюу 4-6 онооны хооронд гарч байгаа бөгөөд зарим A, G, O, Q₃ үзүүлэлтүүд дунджаас өндөр үзүүлэлттэй гарсан байна. Судалгаанд оролцсон оюутны сэтгэлгээний цар хүрээг илэрхийлсэн B хүчин зүйлийн тоон үзүүлэлт/2.7/дунджаас доогуур үзүүлэлттэй гарав. Хувь хүний сэтгэлгээний хөгжлийн нэг чухал талыг харуулсан B хүчин зүйлсийн

үзүүлэлт дунджаас доогуур сөрөг тал руугаа гарч байгаа нь бүтээлчээр сэтгэх сэтгэлгээний чадвар хангалтгүй, сэтгэлгээний цар хүрээ өнгөц явцуу, үзэгдэл юмсын хамаарал холбоо, дотоод зүй тогтлыг олж илрүүлэх, хийсвэрлэх, эргэцүүлэн тунгаах оюуны дадал чадвар сул хөгжиж байгааг харуулна. Суралцахуйн агуулга төвтэй сургалтын технологи сургалтад давамгайлсан хэвээр байгаа өнөөгийн тогтолцоо суралцагчдын гарваль ухааныг задалж, оюуны нөөц боломжийг дэмжин хөгжүүлэх, асуудлыг олон талаас авч үзэж, өргөн цар хүрээтэй уян хатан сэтгэх бүтээлч сэтгэлгээ, сэтгэлгээний царааг эрчимжүүлэхэд нөлөөлөх эерэг хүчин зүйлс, хөшүүрэг болж чадахгүй байна. Баримт мэдээлэлд оюун дүгнэлт эргэцүүлэл хийх, тэдгээрийн хамаарал холбоо, дотоод зүй тогтлыг олж илрүүлэх сэтгэхүйн сул чадамж, өнгөц явцуу сэтгэлгээ, залуу хүний үнэт зүйлсийн чухал тал болох бүтээлч чанар хөгжихөд сөргөөр нөлөөлөх учир анхаарал хандуулах шаардлагатай асуудал мөн.

Оюутны хувьд бие хүний сэтгэл хөдлөлийн онцлог талыг илэрхийлэх О үзүүлэлт дунджаас дээгүүр /8.9/ сөрөг тал руугаа гарч байгаа нь хүлцэнгүй, ноомой итгэлгүй, өөнтөгч эмзэг, аймтгай түгшимтгий, өөрийгөө буруутгах зан чанарын хазайлтыг илэрхийлэх бөгөөд сэтгэл хөдлөлөө эергээр илэрхийлэх, хянан зохицуулах чадвар сул хөгжиж байгааг харуулна. Багш, эцэг эхчүүд болон нийгмийн өнөөгийн харьцаа хандлага, гэр бүлийн уур амьсгал, хүүхэд залууст ээлтэй орчин болж чадахгүй байгаа өнөөгийн нөхцөл байдал айж түгших, сандарч тэвдэх, гутарч эмзэглэх зэрэг сэтгэл хөдлөлийн сул чанар төлөвших хүчин зүйл болж байна гэж үзэж болох юм.

Мөн хүмүүс хоорондын харилцааны онцлогийг илэрхийлсэн L үзүүлэлт дунджаас дээш /6.8/ гарсан нь аливаад эргэлзэх, болгоомжлох, өөрийгөө хэт бөөцийлж хувиа хичээх, бусдын алдаа дутагдлыг хэт дөвийлгөх, өөнтөглөх зан чанарууд давамгайлах хандлагатай байгааг харуулж байна. Хувиа хичээсэн сэрдэмтгий зан чанарууд нь бусад хүмүүстэй учир зүйгээ ололцож асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх, бусдын төлөө анхаарал санаа тавих, тусалж дэмжих, хамтран багаар ажиллах, санаа бодлоо нээлттэй илэрхийлэх харилцааны соёл, эерэг чадвар хөгжихөд нөлөөлөх нэг хүчин зүйл болно. Энэ нь оюутны үнэт зүйлсийн чухал бүрэлдэхүүн хэсэг болох өөдрөг үзэл, хамтач үзлийн баримжаалал хөгжихөд нөлөөлөх хүчин зүйл болж байгааг анхааран үзэж, нарийвчлан

судлах шаардлагатай асуудал болж байна.

Дүгнэлт

1. Оюутны сэтгэл хөдлөлд хүлцэнгүй, ноомой, өөртөө итгэлгүй, өөнтөгч, эмзэг түгшимтгий зан чанарууд давамгайлах хандлагатай байгаа бөгөөд багш, эцэг эхчүүд болон нийгмийн өнөөгийн харилцаа хандлага, гэр бүлийн уур амьсгал, хүүхэдтэй ажиллах арга барил нөлөөлж байна.
2. Бусдын санаа бодолд эргэлзэж тээнэгэлзэх, болгоомжлох, өөрийгөө бөөцийлж хувиа хичээх, бусдын алдаа дутагдлыг дөвийлгөн өөнтөглөх зэрэг зан чанарууд судалгаанд оролцсон оюутны харилцааны онцлог сул талыг тодорхойлж байна. Айж түгших, сандарч тэвдэх, гутарч эмзэглэх зэрэг сэтгэл хөдлөлийн сул тал, хувиа хичээх, сэрдэмтгий зан чанарууд оюутны үнэт зүйлсийн чухал бүрэлдэхүүн хэсэг болох өөдрөг үзэл, хамтач үзлийн үнэлэмж баримжаалал хөгжихөд нөлөөлөх нэг хүчин зүйл болж болохыг анхааран үзэж, нарийвчлан судалж, тусгайлан ажиллах шаардлагатай асуудал болж байна.
3. Оюутны үзэгдэл юмсын учир шалтгаан, хамаарал холбоо, зүй тогтлыг илрүүлэх, эргэцүүлэл шинжилгээ хийх танин мэдэхүйн чадамж хангалтгүй, хэвшмэл загварын өнгөц сэтгэлгээ давамгайлах хандлагатай байгааг судалгааны үр дүн харуулав. Өнгөц явцуу, хэвшмэл загварын сэтгэлгээ, танин мэдэхүйн чадвар давамгайлж байгаа нь залуу хүний үнэт зүйлсийн чухал тал болох бүтээлч чанар хөгжихөд нөлөөлөх хүчин зүйл болж байна.
4. Бие хүний сэтгэл зүйн онцлогийг судалснаар оюутан, сурагчдын бие хүн болон төлөвших явцад тохиолдож буй гажуудал хоцрогдол дутагдалтай талыг илрүүлэх төдийгүй тэдний үнэт зүйлсийн баримжаалалд нөлөөлөх нөлөөллийг судлах таатай боломж бүрдүүлэх учир энэ чиглэлийн судалгааг өргөжүүлэн хөгжүүлэх эрэлт хэрэгцээ тулгамдаж байна.

Ашигласан материал

- Андреева, Г.М. (1997). Социальная психология. Учебник для высших учебных заведений. Москва. “Аспект” Пресс.
- Allport, G. W. (1960). The open system in personality

- theory. *Journal of Abnormal and Social Psychology*
- Бубнова, С.С. (1997). Принципы и методы исследования ценностных ориентаций личности как системы с нелинейной структурой. *Психологическое обозрение*, №1.
- Каширский, Д.В. (2014). Психологический подход к анализу ценностей в студенческом возрасте. *Вестник Алтайской академии экономики и права*. № 2.
- Мясищев, В.Н. (1997). Структура личности и отношение человека к действительности / *Психология личности*/, т.2 Самара: Изд. Дом "Бахрах",
- Rotter, J.B. (1982). *The development and applications of social learning theory: Selected papers*. New York: Praeger.
- Rokeach, M. (1973). *The Nature of Human Values Text*. Moscow

Analysis on the studies of relationships between student's individuality and values

E.Narantungalag
Mongolian National University of Education School of Physical Education
Department of Physical Education and Sports theory

Abstract

The paper intends to present the analysis of the survey results on the first year students of MNUE that aimed to investigate students' personal psychological characteristics. In total 194 students from School of Social Sciences and Humanities, School of Mathematics, and Natural Sciences, and Teacher Training College have been involved in the current survey. The R.Kettel's C version of the 16 indicator-test for comprehensive study of personal characteristics was employed and L and O indicators were used to reveal students' communication and emotional state and they were above the average. The study shows that most students have more negative characteristics such as hesitation, paying more attention to others' mistakes, fear, low self-esteem, low self-confidence, and depression towards any problems. However, B indicators were (2,7) below the average which shows that low cognitive and limited development have impact on students' thinking and imagination. Therefore, it was concluded that the survey needs to be extended and elaborated because of the interrelations of students' psychological characteristics and their orientation and structure of values.

Key word

Personal psychological characteristics, test of 16 factors to identify individual psychological characteristics, orientation of values